Grant Thornton

Тусдаа санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

“Инвескор ББСБ” ХК

2022 оны 12 дугаар сарын 31



Агуулга

Хараат бус аудиторын дүгнэлт	4
Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	8
Тусдаа санхүү байдлын тайлан	10
Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан	11
Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан	12
Тусдаа санхүүгийн тайлангийн тодруулгууд	14

ББСБ-ын талаарх мэдээлэл

ББСБ-ын нэр:	“Инвескор ББСБ” ХК	
Үүсгэн байгуулах шийдвэр:	“Инвескор ББСБ” ХК нь 2016 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр анх үүсгэн байгуулагдсан.	
Гэрчилгээ ба лиценз	Монгол улсын Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж 9015003118 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар тогтоолоор банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/554 тоот гэрчилгээ авсан.	
Төлөөлөн удирдах зөвлөл	Дарга	Б.Анхболд (“Эс Ай Би Жэй Капитал” ХХК, Гүйцэтгэх захирал)
	Гишүүд	Д.Баясгалан (“Инвескор ББСБ” ХК, Гүйцэтгэх захирал)
		Р.Пүрэв (“Эс Ай Би Жэй Капитал” ХХК, Дэд захирал)
		Г.Уянгахишиг (“Инвескор Капитал ҮЦК” ХХК, ТУЗ-ийн дарга)
		Т.Тэлмэн (“Амар даатгал” ХХК, Бизнес хөгжлийн газрын захирал)
		Намики Хирохито (“Инвескор Жапан” ХХК, Гүйцэтгэх захирал)
	Хараат бус гишүүн	Ч.Хашчулуун (МУИС-ын Эдийн засгийн тэнхмийн Профессор)
		Д.Энхбат (“Хархорум Дижитал” ХХК, Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал)
		Ч.Өнөржаргал (СЭЗИС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн ахлах багш)
Удирдлагын баг:	Гүйцэтгэх захирал	Д.Баясгалан
	Тэргүүн дэд захирал	Н.Арсланбаатар
	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал	Г.Жавхлант
	Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал	С.Тулга
	Дотоод аудитын газрын захирал	М.Нямсүрэн
	Үйл ажиллагааны газрын захирал	Ш.Эрдэнэбилэг
	Санхүү бүртгэл тайлагналын газрын захирал	Ш.Цэрэндаваа
	Хүний нөөцийн газрын захирал	Ц.Нэмэхбаяр
	Систем удирдлагын газрын захирал	Б.Онолбаяр
	Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал	Ө.Билгүүн
	Бизнес хөгжил, инновацийн газрын захирал	Ж.Бямба-Эрдэнэ
	Салбарын удирдлагын газрын захирал	Э.Эрдэнэхүү
	Хууль, эрсдэлийн удирдлагын газрын захирал	Ц.Алтаннавч
Хаяг:	Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парисын гудамж, IC тауэр, 14 давхар	

Регистрийн дугаар:	6060854
Үйл ажиллагаа:	• Зээлийн үйл ажиллагаа • Факторингийн үйл ажиллагаа • Итгэлцлийн үйлчилгээ • Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх • Хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх • Төлбөрийн баталгаа гаргах
Ажиллагсадын тоо:	177
Аудитор:	"Грант Торнтон Аудит" ХХК, Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага

Grant Thornton

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар

Монгол улсын ББСБ-ын тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, ББСБ-ын дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Бид тусдаа санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагад мөрдүүлэхээр зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журмын даган мөрдөлтийн талаар тест гүйцэтгэсэн бөгөөд Монгол улсын хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, журмыг ноцтойгоор зөрчсөн гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Эрдэнэцог болно.

GRANT THORNTON AUDIT LLC
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ

.....
Б.ӨСОРГАРАВ
УДИРДАХ ПАРТНЕР

.....
Н.ЭРДЭНЭЦОГ
ГЭРЭЭТ АЖЛЫН ПАРТНЕР

2023 оны 03 дугаар сарын 01
Улаанбаатар хот

Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,
ЮНЕСКО гудамж - 31,
Сүхбаатар дүүрэг,
1 хороо Улаанбаатар
14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,
UNESCO street - 31,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230,
Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

Хараат бус аудиторын дүгнэлт

"Инвескор ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Инвескор ББСБ" ХК (цаашид "ББСБ" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан,
- Тусдаа санхүүгийн байдлын тайлан,
- Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан,
- Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Инвескор ББСБ" ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх тусдаа санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

Хараат бус байдал

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус ББСБ-с хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

Аудитын аргачлалын хураангуй

Аудитын гол асуудлууд	•	ББСБ нь зээлийн авлагыг СТОУС 9 "Санхүүгийн хэрэглүүр"-н дагуу гурван шатлалд ангилан хүлээгдэж буй алдагдлын загвараар үнэ цэнийн бууралтыг тооцсон.
Материаллаг байдал	•	Тусдаа санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 1,497,087.4 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 2 хувиар тооцсон.
	•	ББСБ нь хувьцаагаа олон нийтэд гаргасан олон нийтийн сонирхол бүхий компани учир татварын өмнөх ашиг болон нийт орлогыг материаллаг тооцоолох суурь үзүүлэлтээр сонгосон бөгөөд ББСБ-н дотоод ажилчдын асуулгын үр дүн, өмнөх аудитын зөвлөмж, тайланд үндэслэн эрсдэлийг дундаж гэж үзэн хувь хэмжээг 2 хувиар тооцсон.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	***Аудитын гол асуудалд авсан аудиторын хариу арга хэмжээ***
Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт: ББСБ нь харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтыг зээлийн бүтээгдэхүүн тус бүрийн хувьд өмнөх тайлант үеүдийн зээлийн алдагдлын түүхэн мэдээлэл болон макро эдийн засгийн хүчин зүйлсийн нөлөөллийг авч үзэн, магадлалаар таамагласан ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцоолох байдлаар загварчилсан байна. Тайлант онд энэхүү загварын дагуу харилцагчдад олгосон зээл болон түүнтэй адилтгах хөрөнгийг СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр”-н дагуу гурван шатлалд ангилан хүлээгдэж буй алдагдлын загвараар үнэ цэнийн бууралтыг тооцоолсон байна. Ашигласан үзүүлэлт, удирдлагын таамаглалууд нь тохиромжгүй байж болзошгүй бөгөөд тооцооллын үр дүн материаллаг учир бид энэхүү тооцооллыг аудитын гол асуудалд оруулсан.	Зээлийн үнэ цэнийн тооцооллыг үнэлэхдээ дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд: • ББСБ-ын зээлийн үнэ цэнийн бууралтын тооцоололд ашигласан зээлийн өгөгдлийн иж бүрэн байдал, ашигласан мэдээллийн найдвартай байдлыг шалгасан, • Зээлийн бүлгийн ангилалд багтсан зээлүүдийн ангилал болон насжилт зөв эсэхийг шалгаж, зохих журмын дагуу ангилсан эсэхийг хянасан, • Зээлийн үнэ цэнийн бууралтыг тодорхойлоход удирдлагын зүгээс ашигласан магадлалуудыг ББСБ-ын зээлийн мэдээлэлтэй тулгасан, • Хүлээгдэж буй зээлийн алдагдалтай холбоотой нэмэлт тодруулгууд нь хангалттай эсэхийг үнэлсэн, • Тооцоололд ашигласан макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг өөрчлөх байдлаар давтан тооцоолоход ББСБ-ын ашигласан аргачлалаар тооцоолсон хүлээгдэж буй алдагдлын дүн нь болон бидний тооцоолсон дүнгийн зөрүү нь бидний тогтоосон материаллагийн дүнгээс хэтрээгүй байсан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл ББСБ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин тусдаа санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Тусдаа санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Тусдаа санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь Тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн тусдаа Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

ББСБ-ын удирдлага эдгээр Тусдаа санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь Тусдаа санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ ББСБ-ын үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах ЬЬСЬ-ын чадамжийг үнэлэх,

боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь ББСБ-ын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс Тусдаа санхүүгийн тайлан нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ Тусдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас Тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- ББСБ-ын дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн ББСБ-ын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа Тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал ББСБ тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад Тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж Тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Удирдлагын мэдэгдэл

Удирдлага нь тусдаа санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж, ББСБ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусвар болсон үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу зохистой толилуулах үүрэгтэй.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага дараах үүрэг хариуцлагыг биелүүлсэн. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгох, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн.

- ББСБ-ын эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн.

- Тусдаа санхүүгийн тайланг тасралтгүй үйл ажиллагаанд үндэслэн бэлтгэсэн.

- Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага, болзошгүй зүйлсийн талаар тодруулсан.

“Инвескор ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн дарга Б.Анхболд, Гүйцэтгэх захирал Д.Баясгалан болон Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал С.Тулга бид энэхүү тайлангийн 14-63 дугаар хуудсанд үзүүлсэн ББСБ-ын санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ББСБ-ын санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ТУЗ-ийн дарга	Гүйцэтгэх захирал	Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал
Б.Анхболд	Д.Баясгалан	С.Тулга
Огноо: 2023/03/01	Огноо: 2023/03/01	Огноо: 2023/03/01

Тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Үр ашигт хүүгийн аргыг ашиглан тооцсон хүүгийн орлого	8	61,726,592	32,536,797
Хүүний зардал	8	(24,262,873)	(12,272,582)
Цэвэр хүүний орлого	**8**	**37,463,719**	**20,264,215**
Хураамж, шимтгэлийн орлого	9	13,127,780	8,778,941
Хураамж, шимтгэлийн зардал	9	(748,025)	(392,557)
Хураамж, шимтгэлийн цэвэр орлого	9	**12,379,755**	**8,386,384**
Арилжааны цэвэр олз (гарз)	10	**(39,430)**	**(157,063)**
Бусад орлого		332,346	174,452
Үнэ цэнийн бууралтын алдагдал/буцаалт	11	(5,285,550)	(627,836)
Ажилтнуудтай холбоотой зардал	12	(5,873,981)	(3,814,127)
Элэгдэл, хорогдлын зардал		(1,651,334)	(1,384,955)
Үйл ажиллагааны болон бусад зардал	13	(5,027,656)	(2,961,931)
Үйл ажиллагааны ашиг		**(17,506,175)**	**(8,614,397)**
Татварын өмнөх ашиг		**32,297,869**	**19,879,139**
Орлогын албан татварын зардал	14	(7,566,966)	(4,066,461)
Татварын дараах ашиг		**24,730,903**	**15,812,678**

Хуудас 14-с 63-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа санхүү байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15	42,280,647	17,225,123
Харилцагчдад олгосон зээл - цэвэр	16	266,186,479	171,037,819
Бусад санхүүгийн хөрөнгө - цэвэр	17	2,774,004	4,218,255
Өрийн болон өмчийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт	18.1	6,960,216	187,500
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	18.2	5,803,354	5,803,354
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	19	561,450	783,568
Бусад санхүүгийн бус хөрөнгө	20	3,401,746	1,563,537
Үндсэн хөрөнгө	21	1,243,735	1,179,554
Биет бус хөрөнгө-цэвэр	22	3,709,487	2,606,778
Хөрөнгө ашиглах эрх-цэвэр	23	810,285	740,218
Нийт хөрөнгө		**333,731,403**	**205,345,706**
Өр төлбөр ба эздийн өмч			
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр	24	85,440,869	56,477,725
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	25	63,749,950	34,159,729
Бусад эх үүсвэр	26	26,432,767	10,219,535
ББСБ-аас гаргасан бонд	27	44,170,514	27,620,907
Бусад санхүүгийн өр төлбөр	28	1,384,102	2,998,642
Санхүүгийн бус өр төлбөр	29	1,424,866	1,065,492
Нөөц өр төлбөр	30	774,303	774,303
Орлогын албан татварын өглөг	31	1,510,227	1,603,045
Хойшлогдсон татварын өр төлбөр	32	456,035	314,335
Өр төлбөрийн нийт дүн		**225,343,633**	**135,233,713**

Тусдаа санхүүгийн байдлын тайлан *(үргэлжлэл)*

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл
Эздийн өмч			
Хувьцаат капитал	33.1	17,193,952	16,282,237
Нэмж төлөгдсөн капитал	33.3	29,820,733	15,377,738
Дахин үнэлгээний нэмэгдэл	33.4	(16,638)	-
Хуримтлагдсан ашиг	33.5	56,389,723	33,452,018
Эздийн өмчийн бусад хэсэг	34	5,000,000	5,000,000
Эздийн өмчийн дүн		**108,387,770**	**70,111,993**
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		**333,731,403**	**205,345,706**

Уг тусдаа санхүүгийн байдлын тайлан 2023 оны 03 дугаар сарын 01-нд батлав:

ТУЗ-ийн дарга

Б.Анхболд

Огноо: 2023/03/01

Гүйцэтгэх захирал

Д.Баясгалан

Огноо: 2023/03/01

Санхүү удирдлага, хөрөнгө зохицуулалтын газрын захирал

С.Тулга

Огноо: 2023/03/01

Хуудас 14-с 63-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Эздийн өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагд сан ашиг	Нийт дүн
2021 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	**16,282,237**	**15,377,738**	**-**	**-**	**18,858,712**	**50,518,687**
Тайлант хугацааны өөрчлөлт	-	-	-	5,000,000	-	5,000,000
Олгосон ногдол ашиг	-	-	-	-	(1,219,372)	(1,219,372)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	-	15,812,678	15,812,678
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**16,282,237**	**15,377,738**	**-**	**5,000,000**	**33,452,018**	**70,111,993**
Тайлант хугацааны өөрчлөлт	911,715	14,442,995	(16,638)			15,338,072
Олгосон ногдол ашиг					(1,793,198)	(1,793,198)
Тайлант үеийн цэвэр ашиг					24,730,903	24,730,903
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	**17,193,952**	**29,820,733**	**(16,638)**	**5,000,000**	**56,389,723**	**108,387,770**

Хуудас 14-с 63-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Татварын өмнөх ашиг		**32,297,869**	**19,879,139**
Тохируулга:			
Элэгдэл, хорогдлын зардал	21-23	1,651,334	1,384,955
Валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй гарз, (олз)	10	6,084	123,605
ӨБҮХХ-ийн үнэ цэнийн бууралтын гарз	11	170,357	288,474
Зээлийн авлагын хүлээгдэж буй алдагдал	11	4,703,385	520,045
Санхүүгийн хөрөнгө дах үнэ цэнийн бууралт	11	411,808	(180,683)
Хөрөнгө данснаас хассаны гарз (олз)	13	26,975	2,052
Санхүүгийн зардал	8	24,188,825	12,204,643
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	8	74,048	67,939
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны алдагдал		**63,530,685**	**34,290,169**
Харилцагчдад олгосон зээлийн (өсөлт)/бууралт	16	(95,751,587)	(77,722,031)
Бусад санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн (өсөлт)/бууралт	17, 20	(393,961)	(3,876,238)
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн (өсөлт)/бууралт	19	222,119	38,324
Бусад санхүүгийн болон санхүүгийн бус өр төлбөрийн (өсөлт)/бууралт	28-29	1,255,166	(1,167,386)
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгө		**(31,137,578)**	**(48,437,162)**
Төлсөн орлогын албан татвар	31	(7,513,311)	(2,998,929)
Төлсөн хүү	24-27	(18,012,099)	(12,204,642)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(56,662,988)**	**(63,640,733)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	21	(1,099,558)	(595,494)
Борлуулсан үндсэн хөрөнгө	21	614,393	-
Түрээсээр олж эзэмшсэн хөрөнгө ашиглах эрх	23	593,349	459,664

Тусдаа мөнгөн гүйлгээний тайлан *(үргэлжлэл)*

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
Худалдан авсан биет бус хөрөнгө	22	(1,707,198)	(119,793)
Борлуулсан хөрөнгө оруулалт	18	245,759	591,123
Худалдан авсан хөрөнгө оруулалт	18	6,772,715	(187,500)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**5,419,460**	**148,000**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Бонд гаргалтаас хүлээн авсан	27	26,260,000	23,740,000
Бондын эргэн төлөлт	27	(9,667,200)	(4,349,000)
Бусдаас авсан зээл	25,35	77,582,102	47,137,957
Зээлийн эргэн төлөлт	25,35	(48,449,172)	(22,600,918)
Харилцагчаас татсан итгэлцэл	35	82,478,317	27,619,044
Харилцагчид төлсөн итгэлцэл	35	(51,824,865)	(20,949,042)
Хоёрдогч өглөгөөр татсан өр төлбөр	34	-	5,000,000
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлөлт		(74,048)	(67,939)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**76,305,134**	**55,530,102**
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн гадаад валютын ханшийн тэгшитгэл		(6,082)	(104,393)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		25,055,524	(8,067,024)
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	15	**17,225,123**	**25,292,147**
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15	**42,280,647**	**17,225,123**

Хуудас 14-с 63-д харуулсан тодруулгууд нь энэхүү тусдаа мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.